



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/03/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2023 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙД ҮЙЛДВЭРЛЭВ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ц.ЛУВААНЖАЛБУУ ТАНАА

2023.03.15 № 129
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ нь түрээсийн үйл ажиллагаа явуулдаг ба тайлант онд өөрийн барилгын халаалтын зуухыг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Аймгийн Хөгжимт драмын театрын балансад шилжүүлэн өгсөн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь худалдааны заал, талбайг бусдад түрээслүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж 2022 онд 2700 м.кв 5 давхар байрыг 126 иргэн, аж ахуйн нэгжид түрээсийн гэрээгээр түрээсэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	19,157,908.69	46,847,256.68
1.1.2	Дансны авлага	5,805,330.00	4,396,750.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,104,495.00	1,144,495.00
1.1.6	Бараа материал	10,180,340.00	4,177,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	36,248,073.69	56,565,501.68
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,116,299,322.76	2,819,950,367.59
1.2.2	Биет бус хөрөнгө	12,084,000.00	12,552,666.67
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,128,383,322.76	2,832,503,034.26
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,164,631,396.45	2,889,068,535.94
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		34,383.87
2.1.1.3	Татварын өр	10,357,424.79	3,724,356.92
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	25,058,890.00	28,708,710.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	35,416,314.79	32,467,450.79
2.2.20	Өр төлбөрийн нийт дүн	35,416,314.79	32,467,450.79
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч: - төрийн	3,154,084,200.00	3,154,084,200.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-24,869,118.34	-297,483,114.85
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,129,215,081.66	2,856,601,085.15
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,164,631,396.45	2,889,068,535.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	153,852,163.93	177,341,072.73
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	153,852,163.93	177,341,072.73
4	Түрээсийн орлого	153,852,163.93	177,341,072.73
5	Хүүний орлого	2,837,060.00	
6	Бусад орлого	40,562,429.00	26,441,774.00
7	Ерөнхий ба удирдлагын зардал	227,238,405.02	230,418,787.57
8	Санхүүгийн зардал	111,800.00	132,900.00
9	Бусад зардал	861,037.49	68,782.00
10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз/		(245,928,040.34)
11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(30,959,589.58)	(272,765,663.18)
12	Орлогын татварын зардал	-	
13	Татварын дараах ашиг (алдагдал)	(30,959,589.58)	(272,765,663.18)
14	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(30,959,589.58)	(272,765,663.18)
15	Орлогын нийт дүн	(30,959,589.58)	(272,765,663.18)
16	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0	0

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,154,084,200.00	4,202,028.58	3,158,286,228.58
2	Залруулсан үлдэгдэл			
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		1,888,442.66	1,888,442.66
4	Залруулсан үлдэгдэл			
5	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал		-30,959,589.58	-30,959,589.58
6	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,154,084,200.00	(24,869,118.34)	3,129,215,081.66
7	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,154,084,200.00	(24,869,118.34)	3,129,215,081.66
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		151,666.67	151,666.67
9	Залруулсан үлдэгдэл			
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(272,765,663.18)	(272,765,663.18)
11	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,154,084,200.00	(297,483,114.85)	2,856,601,085.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	199,196,494.00	217,705,912.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	155,908,965.00	192,521,735.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	43,287,529.00	25,184,177.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	191,438,506.75	191,413,624.01
	Ажиллагчдад төлсөн	60,295,242.00	66,609,426.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	17,868,435.17	18,673,347.17
	Бараа материал худалдан авахад төлсөн	32,267,375.00	15,675,170.00
	Ашиглалтын зардалд төлсөн	39,030,721.68	48,049,069.58
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,092,570.00	
	Татварын байгууллагад төлсөн	37,589,955.41	37,216,708.26
	Даатгалын төлбөр төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	3,294,207.49	5,189,903.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,757,987.25	26,292,287.99
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,579,725.00	9,058,360.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	2,743,325.00	
	Бусад орлого	4,836,400.00	9,058,360.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,258,800.00	7,661,200.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,958,900.00	7,661,200.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	299,900.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,320,925.00	1,397,160.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	13,078,912.25	27,689,447.99
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,078,996.44	19,157,908.69
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,157,908.69	46,847,356.68

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	х.нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	мян.төг	197,251.50	198,747.60	217,705.90	- 18,958.30	65.2
2	а/ Түрээсийн орлого	мян.төг	153,852.10	182,469.60	192,521.70	- 10,052.10	2.8
3	б/ Бусад орлого	мян.төг	43,399.40	16,278.00	25,184.20	-8,906.20	62.4
4	Нийт зардал	мян.төг	228,211.30	191,835.60	191,413.62	421.98	148.4
5	Үүнээс; Удирдлагын зардал	мян.төг	227,238.40	191,835.60	191,413.62	421.98	148.4
6	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	-30,959.60	6,912.00	26,292.28	- 19,380.28	-83.2
9	а/Орлогын татварт	мян.төг	70				
10	б/НӨТ	мян.төг	7,426.50				
11	в/НДШ	мян.төг	9,005.50				
12	г/Хүн амын орлогын албан татвар	мян.төг	3,449.20				
13	д/Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	28,386.70	28,386.70	26,859.20	1,527.50	94.6
14	ж/Бусад татвар	мян.төг		275.80	75.8	200.00	27.5
16	Нийт ажиллагсдын тоо	хүн	11	11	11	0.00	100
17	Нийт цалингийн сан	мян.төг	81,666.70	86,997.90	85,282.70	1,715.20	98
18	Хөрөнгө оруулалт	мян.төг	2,258.80		-	-	
19	Нийт авлага	мян.төг	6,909.80		5,541.30	-5,541.30	
21	Нийт өглөг	мян.төг	35,416.30		32,467.50	- 32,467.50	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 4,604.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 846.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,758.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 299.9 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингаас ХХОАТ буруу тооцоолсон	1	69.40					1	69.4				
Тэтгэвэрт гарсан хүнийг 10.11 сард түр ажлуулахдаа НДШ буруу суутгасан	1	22.40					1	22.4				
Цалингийн татвар тооцооллын алдаанаас үүдэж цалингийн зөрүү үүссэн	1	34.40					1	34.4				
Үндсэн хөрөнгийн тайланд бараа материалын шинж чанартай хөрөнгө бүртгэлтэй байна	1	420.00					1	420.0				
Дүн	4	546.2					4	546.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийг зохистой удирдаагүйгээс цалин, татварын өрийн үлдэгдэлтэй	1	3,758.7			1	3,758.7						
Үлдэх өртөггүй, ашиглах хугацааг буруу бүртгэсэн	1	299.9					1	299.9				
Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ гаргасан	1	0					1	0				
Дүн	3	4,058.6			3	3,758.7	3	299.9				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Мянган төгрөг

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны сайтад 88 мэдээлэл байршуулахаас 61 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан, цалингаас бусад 5 сая төгрөгнөөс дээш орлого, зарлагыг мэдээллэхээс орлого болон зарлагыг дутуу мэдээллэсэн	1	3,758.7			1	3,758.7		
Дүн	1	3,758.7				3,758.7		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
6	ТӨОНААТҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			